

Фридрих Ницше болон Жан-Поль Сартрын философи дахь эрх чөлөө ба ёс зүйн харилцаа хамаарлын тухай асуудал

Б.Дагзмаа, доктор (Ph.D), профессор
МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим
Б.Горхи, магистрант
МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим

Хураангуй: *Фридрих Ницше болон Жан-Поль Сартрын философид эрх чөлөө нь ёс зүйтэй холбогдон яригддаг. Ницшегийн хувьд эрх чөлөө нь хүний дотоод хүч, өөрийгөө бүтээх “эзэрхэх хүсэл эрмэлзлэл”-ийн илэрхийлэл бөгөөд уламжлалт ёс суртахууны хязгаарыг даван туулах замаар илэрдэг. Түүний үзэл баримтлалд эрх чөлөө нь ёс суртахууныг дагах бус, түүнийг давж, шинэ үнэлэмжийг бүтээх чадавх юм. Харин Сартрын философид эрх чөлөө нь хүний ухамсартай салшгүй холбоотой бөгөөд хүн туйлын эрх чөлөөнд оршиноор ёс зүйн хариуцлагаа бүрэн ухамсарлах шаардлагатай болдог. Иймээс эрх чөлөө нь зөвхөн сонголт хийх боломж төдийгүй, ёс зүйн суурь нөхцөл болдог. Энэхүү өгүүлэл нь энэ хоёр сэтгэгчийн эрх чөлөөний тухай ойлголтыг ёс зүйн байр суурьтай нь уялдуулан шинжилж, тэдгээрийн хоорондын онолын ялгаа болон төсөөтэй талуудыг тодруулан, эрх чөлөө ба ёс зүйн харилцаа хамаарлыг философийн үүднээс шүүн хэлэлцэхийг зорьсон болно. Ингэснээр эрх чөлөөг зөвхөн субъектив мэдрэмж бус, ёс зүйн хүрээнд шинээр тодорхойлох боломж нээгдэнэ. Мөн энэ харьцуулалт нь орчин үеийн ёс зүйн асуудлыг шинэ өнцгөөс харах онолын үндэс суурийг бүрдүүлнэ.*

Түлхүүр үг: үлэмж хүн, эзэрхэх хүсэл эрмэлзлэл, уламжлалт ёс суртахуун, нигилизм, ухамсар, өөрөөрөө байгаа ахуй, өөрийн төлөөх ахуй, хуурамч итгэл

Фридрих Ницше эрх чөлөөний тухай тусгай ойлголт боловсруулаагүй ч түүний номыг унших бүрд эрх чөлөөг гүнээ мэдэрдэг билээ. Тэрбээр эрх чөлөөний тухай санаагаа “Эзэрхэх хүсэл эрмэлзлэл”, “Үлэмж хүн”, “Мөнхийн буцалт” зэрэг чухал ойлголтууддаа шингээсэн байдаг. Харин Жан Поль Сартрын эрх чөлөөний үзэл нь “Өөрийн төлөөх ахуй”, “Юу ч биш”, “Хуурамч итгэл” зэрэг ойлголтуудтай холбоотой. Түүний “Ахуй ба юу ч биш” зохиолыг нэг ёсондоо эрх чөлөөний тухай бүтээл гэж болох юм. Тэрбээр тус бүтээлдээ “хэрэв бид Ницшегийн “үзэгдлийн (apparence) цаадах ертөнц” гэх хоосон итгэлээс салбал, хэрэв бид “үзэгдлийн цаадах ахуй”-д итгэхээ боливол үзэгдэл бүрэн хүлээн зөвшөөрөгдөхүйц зүйл болно. Үзэгдлийн мөн чанар нь илрэхүйд л оршино, тиймээс энэ нь ахуйтай сөргөлдөх зүйл биш, харин ахуйн хэмжүүр болж хувирна (Сартр, Ахуй ба юу ч биш, 2014)” гэж бичжээ. Өөрөөр хэлбэл, Ницше болон Сартр боловсруулсан эрх чөлөөний тухай философи үзэл нь цаана нягт холбоотой бөгөөд ёс суртахуунтай ямар нэгэн байдлаар холбогдож гарч ирдэг юм.

Ф.Ницшегийн зохиолд эрх чөлөөний тухай олонтоо дурддаг ч эрх чөлөө гэж юу болох тодорхойлолт ховор дайралддаг. Тэгвэл Ж.П.Сартр эрх чөлөө бол ямар ч мөн чанаргүй бөгөөд эрх чөлөө нь аливаа зүйлийн мөн чанар, үндэс болж байдаг гэсэн бол Ницше ч эрх чөлөө бол сэтгэгдэшгүй зүйл гэж бичсэн үе бий. Гэвч Ницше “Эзэрхэх хүсэл эрмэлзлэл” гэх номын сүүл хэсэгт “энэхүү номыг цөөнх эрх чөлөөтэй хүмүүст зориулав, тэдний хувьд бүх зүйл хориггүй, бид аливаа юмсын тухай эрх мэдлээ эгүүлэн авсан” гэдэг санаагаа илэрхийлсэн байдаг.

Ф.Ницшегийн “эрх чөлөө бол хүсэл эрмэлзлэлийг бататгах, эзэрхэх хүсэл эрмэлзлэл мөн” (Ницше, 1991, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, х.560) гэх тодорхойлолтоос харахад Ницшегийн хувьд эрх чөлөө бол яалт ч үгүй эзэрхэх хүсэл эрмэлзлэлтэй

холбоотой зүйл юм. Иймээс эзэрхэх хүсэл эрмэлзлэл гэж юу болохыг тодруулах нь түүний эрх чөлөөний тухай үзлийг ойлгоход тэргүүн үүрэг болж байна.

“Хүн үлэмж эзэрхэх хүсэл эрмэлзлэл болсны хувьд хүнд өөрийгөө илэрхийлэх олон хэрэгсэл, хэлбэр байдаг” (Ф.Ницше, *Эзэрхэх хүсэл эрмэлзлэл*, 2011, х.22), “үнэлэмж жич түүний хувиралт нь үнэлэмж тогтоогчийн (хүн) эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн өсөлтөөс шалтгаална” (Ф.Ницше, *Эзэрхэх хүсэл эрмэлзлэл* 2011, х. 403) гэж тэрээр бичсэн байна. Өөрөөр хэлбэл хүн бүхэлдээ эзэрхэх хүсэл эрмэлзлэл бөгөөд үнэлгээ өгөгч, шинэ үнэлэмжийг бүтээгч юм. Ницше үнэлгээ өгөх ч нэг зүйлийн эзэрхэх хүсэл эрмэлзлэл мөн гэжээ.

Хэдийгээр хүн бол эзэрхэх хүсэл эрмэлзлэл, эрх чөлөө бол эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бататгах гэдгийг мэдсэн ч бидэнд эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг хэрхэн бататгах вэ гэдэг асуудал тулгарч байна. Үүнд Ницше хүний сэтгэхүйн үйлдлийг хоёр төрөлд хуваасан бөгөөд сэтгэхүй өөрөө үнэлгээ өгөхөөр дамжин илэрдэг гэж үзжээ. Анхдагч сэтгэхүйн үйлдэл бол батлах ба үгүйсгэх, сэтгэхүй болон үнэлгээний нэгдэл нь эзэрхэх хүсэл эрмэлзлэл мөн (Ф.Ницше, *Эзэрхэх хүсэл эрмэлзлэл*, 2011, х.16). Өөрөөр хэлбэл хүн бол цорын ганц үнэлгээ өгөгч, үнэлгээ нь батлах буюу үгүйсгэх хэлбэрийн аль нэгээр илэрч байдаг. Ницшегийн үзлээр эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бататгах нь амьдралын хүчийг мэдэрч, улмаар хөгжиж өргөжих явдал юм. Харин эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг үгүйсгэх нь хүнийг сул дорой болгож, улмаар хүн зөвхөн өөрийгөө хамгаалж үлдээхийг хүсдэг болно.

Фридрих Ницшегийнхээр хүсэл эрмэлзлэлийг туйлбартай үгүйсгэсэн хамгийн тод томруун жишээ бол уламжлалт ёс суртахуун юм. Бүхий л ёс суртахуун амьдралыг үгүйсгэдэг (Ф.Ницше, *Эзэрхэх хүсэл эрмэлзлэл*, 2011, х.1051), ёс суртахуун нь амьдралыг үгүйсгэж байдаг зайлшгүй зүйл, хүнийг чөлөөлөхийн тулд ёс суртахууныг устгах ёстой (Ф.Ницше, *Эзэрхэх хүсэл эрмэлзлэл*, 2011, х. 315). Өөрөөр хэлбэл, ёс суртахуун нь хэрэгтээ эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг үгүйсгэдэг, иймээс хүн ёс суртахууныг даван туулж эрх чөлөөтэй болдог. Ницшегийн хувьд эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн үгүйсгэл баталгаа болж хувирах нь эрх чөлөөний бэлгэдэл болбог бол, энэ нь ёс суртахууныг даван туулах явцаар биелэлээ олдог. Германы энэхүү суут сэтгэгч нь ёс суртахуун болон эрх чөлөөний харилцаа хамаарлыг гүнзгийрүүлэн судалж, “сайн” байхыг хүсэх нь хүн төрөлхтний доройтол, эрх чөлөөгүй байдал гэж дүгнэсэн билээ. Хүн төрөлхтөн олон мянган жилийн турш ёс суртахуунаас хамааралтай байж ирсэн нь үнэн боловч ёс суртахууны мөн чанарын асуудлыг тодруулахад түүний үүсэл гарлыг судалж үзэх шаардлагатай.

Ф.Ницше “ёс суртахуунтай болох нь өөрөө доройтол мөн, амьдралыг үгүйсгэдэг ёс суртахуун өөрөө ёс суртахуунлаг биш” (Ф.Ницше, *Эзэрхэх хүсэл эрмэлзлэл*, 2011, х.263) гэж бичжээ. Өөрөөр хэлбэл, уг сэтгэгч ёс суртахуун эхэлж үүссэн цагаас өөртөө нэг зүйлийн үгүйсгэл буюу ёс суртахуунлаг бус зүйл агуулсныг гярхай ажиглажээ. “Шагнал, шийтгэлийг аливаа юмсын үндэс хэмээн зальжнаар тавьжээ” (Ф.Ницше, *Заратустра ингэж хэлсэн*, 2014, х.120) гэж бичсэн байна. Эндээс үзэхэд хүмүүс шагнаж, шийтгэх зэрэг ёс суртахууны үйлдэл, сайн муу зэрэг ёс суртахууны үнэлэмжүүдийг “өөрөөрөө байгаа” юм шиг ашиглаж иржээ. Гэвч Ницше шагнах, шийтгэх нь өөрөө ёс суртахуунлаг үйлдэл биш байж, ёс суртахуун нь хүчтэй нь хүчгүйгээ сургаж, захирч байдгаас үүсэлтэй хэмээн үзжээ.

Ф.Ницшегийн үзлээр ёс суртахуун нь эхлээд шашнаас хамааралгүй байсан аж. Шашинтай нэгдсэн тэр үеэс Бурхан тэнгэр ёс суртахууны хамгийн дээд үнэлэмж болсон юм. “Ёс суртахууны үнэлэмж бол хамгийн дээд үнэлэмж мөн (Ф.Ницше,

Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.1010) ... Иймээс ёс суртахууны дээд үнэлэмж болсон Бурхан тэнгэрийг үгүйсгэхэд бүх үнэлэмжийг хянан шинэчлэх хэрэгтэй. Бүх үнэлэмжийг хянан шинэчлэхэд нигилизмд хандах болно” (Ф.Ницше, Заратустра ингэж хэлсэн, 2014, х.1393) гэж бичсэн байна. Ф.Ницшегийн хувьд нэг талаар хуучирсан үнэлэмжийн тогтолцооноос ангижрах, нөгөө талаар бүтээсэн зүйлээ зоригтой батлах явдал юм. Нигилизм нь дээд үнэлэмжүүдийн уналтыг илэрхийлж байдаг болохоор үр дүнд нь Бурхан тэнгэр үхсэн гэжээ.

“Заратустра ингэж хэлсэн” гэх зохиолын дөрөвдүгээр бүлгийн эхний хэсэгт “Бурханд ч гэсэн өөрийн там бий, тэр нь түүний хүнийг хайрлах хайр; Бурхан үхсэн, хүмүүст энэрэнгүй ханддагаасаа болж үхсэн” (Ф.Ницше, Заратустра ингэж хэлсэн, 2014) гэж бичсэн байдаг. Үүнээс Ницшегийн философид “Бурхан үхсэн” гэдэг нь “хөршөө хайрлах”, “тэгш эрхийг хүсэх”, “хүлцэнгүй энэрэнгүй байх” зэрэг уламжлалт ёс суртахуунтай салшгүй нягт холбоотой байдаг нь тодорхой. Тодруулбал, Ницшегийн үзлээр Бурхан тэнгэрийг хөнөөсөн нь өөр хэн ч биш, нигилист ёс суртахуун өөрөө юм.

Ёс суртахуун өөрөө өөрийгөө үгүйсгэсэн гэхээр сонин биз. Учир нь Ницшегийн философид ёс суртахуун ч эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн нэг хэлбэр мөн. “Ёс суртахууны үнэлэмж нь эзэрхэх хүсэл эрмэлзлэл бөгөөд худал хуурмаг, гүтгэлгийн төлөө зүтгэсээр ирсэн түүхтэй, иймэрхүү эзэрхэх хүсэл эрмэлзлэл нь ямагт хүчирхэг хүмүүсийн эсрэг байдаг” (Ницше, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.50). Өөрөөр хэлбэл, Ницшегийн үзлээр ёс суртахуун нь эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг үгүйсгэх, бататгахаас шалтгаалаад хоёр төрөлд ангилагдаж байна. Үүнд, боолын ёс суртахуун болон эзний ёс суртахуун гэж ангилж болох юм.

Хоёр төрлийн ёс суртахууныг хооронд нь хольж болохгүй. Нэг төрлийн ёс суртахуун нь эрүүл хэвээр байгаа ёс суртахуун бөгөөд аяндаа доройтож эхэлж буй ёс суртахуунаас өөрийгөө хамгаалдаг бол, нөгөө нь яг эсрэгээрээ сул дорой байдлыг өөрийгөө илэрхийлэх, зөвтгөх, улмаар бүр доройтох арга хэрэгсэл болгодог ёс суртахуун юм (Ф.Ницше, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.1168). Амьтай юуг ч, хаана ч харсан эрх мэдлийн хүсэл зориг харагддаг, бүр зарцын хүсэл зоригоос эзэн болох хүсэл харагддаг (Ф.Ницше, Заратустра ингэж хэлсэн, 2014, х.151) гэсэн байна. Үүнд, удаах буюу боолын ёс суртахуун давамгайлж ноёрхож эхэлсэн болохоор Ницше эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг баталж, ёс суртахууны үнэлэмжийг үгүйсгэж, боолын ёс суртахууныг даван туулахыг оролдсон болно.

Бид аль хэдийн хоёр төрлийн эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн тэмцлийг олж харсан. Онцгой тохиолдолд би нэг зарчмыг баримталдаг: өмнө нь сул дорой байсан эзэрхэх хүсэл эрмэлзлэлд зүй ёсны байдал олгож, харин өмнө нь ялалт байгуулсан эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг зүй бус гэж үздэг. (Ф.Ницше, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.1054). Өөрөөр хэлбэл, уг нь боолын ёс суртахуун нь хүчирхэг хүмүүсийг үгүйсгэж ялалт байгуулсан бол эдүгээ Ницше давуу байранд байгаа боолын ёс суртахууныг үгүйсгэж, эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг баталж энэхүү харилцаанд эргүүлэг хийж байгаа юм.

Яагаад боолын ёс суртахуун Бурхан тэнгэрийг хөнөөхөд хүргэсэн бэ гэвэл, тэр нь хүчирхэг, дээд зүйлийн эсрэг байдгаараа нигилизмийн ч нэг хэлбэр юм. Ницше нигилизмыг уламжлалт үнэлэмжүүд (шашин, ёс суртахуун, философийн тогтолцоо) өөрийн хүчээ алдах үйл явц гэж тодорхойлдог. Тэрээр үүнийг “Бурхан үхсэн” гэх алдартай метафороор илэрхийлсэн. Энэ нь христийн болон сонгодог метафизикийн ертөнцийг үзэх үзэл хүчингүй болсон гэсэн санаа юм. Үүнд, сул дорой (идэвхгүй)

нигилизм – амьдралыг утга учиргүй гэж хүлээн авч, ямар ч үйлдэл хийхээс татгалзах. Энэ нь сул дорой байдал, гутрал, бусдын дүрмийг дагах хандлагатай холбоотой. Идэвхтэй нигилизм – хуучин үнэлэмжийг бүрэн устгах гэсэн оролдлого, гэхдээ шинэ үнэ цэнийг бий болгодоггүй. Энэ нь заримдаа анархизм, эвдрэл сүйтгэл, хүчирхийллээр илэрдэг.

Ёс суртахууны үнэлэмжүүд бүгд нигилизм болж хувирдаг (Ф.Ницше, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.366), ёс суртахууныг даван туулах нь нигилизм өөрийгөө даван туулж буй хэрэг юм (Ф.Ницше, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.522). Нигилизмийн дотоодод даван туулаагүй ёс суртахуун байж байдаг (Ф.Ницше, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.149). Тухайлбал, нигилизм хэрхэн, яаж өөрийгөө даван туулах вэ гэвэл, Ф.Ницшегийн үзлээр нигилизм нь дээд үнэлэмжүүдийн уналтыг илэрхийлдэг бөгөөд илүү товчоор хэлбэл нигилист ёс суртахуун өөрөө өөрийгөө үгүйсгэх нь жам ёсны үйл явц юм.

Нигилизм өөрийгөө даван туулах нь өмнөх бүхий л үгүйсгэлийг батлах оролдлого (Ф.Ницше, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.495), өмнөх дээд үнэлэмжүүд бол эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн нэгэн өвөрмөц жишээ, ёс суртахуун ч ёс суртахуунгүйн нэгэн өвөрмөц жишээ (Ф.Ницше, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.1053), нигилизм бол доройтлын логик болохоос өөрөө даван туулах ёстой зүйл биш юм (Ф.Ницше, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.1173). Үүнээс дүгнэхэд, дээд үнэлэмж болсон Бурхан тэнгэр ч цагтаа эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн бүтээл юм, эдүгээ нигилизм хүнээс давсан, амьдралаас давсан дээд үнэлэмжүүдийг үгүйсгэх нь гэдрэгээ эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг баталж байгаа юм. Энэ үед идэвхтэй нигилизм эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн нэг өвөрмөц хэлбэр болж, амьдралыг үгүйсгэдэг идэвхгүй нигилизм буюу ёс суртахууныг үгүйсгэж чаддаг. Үгүйсгэлийн эсрэг хамгийн хүчтэй үгүйсгэл болж, улмаар өөрөө эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн баталгаа болж чаддаг. Тэгэхээр шинэ үнэлэмжийг бүтээх нь мэдээж эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн үүрэг болно. Хэрэв идэвхгүй нигилизмыг даван туулж, шинэ үнэ цэнийг бий болгохгүй бол хүн төрөлхтөн доройтож, уналтад орно. Иймээс эзэрхэх хүсэл эрмэлзлэл нь шинэ үнэлэмжийг бүтээх гэлтгүй бүтээсэн зүйлээ баталж байдаг. Гэвч эзэрхэх хүсэл эрмэлзлэл нь ямар нэгэн дан ойлголт биш, энэ талаар бид судлаач Барреттын эзэрхэх хүсэл эрмэлзлэл бол олон ойлголтыг хамарсан бөгөөд сэтгэл зүйн “нэг гишүүн” мөн гэх үзэлтэй санал нэг байна.

“Эзэрхэх хүсэл эрмэлзлэл нь анхдагч сэтгэл хөдлөлийн хэлбэр бөгөөд бусад сэтгэл хөдлөлүүд бол эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн өргөтгөл юм” (Ф.Ницше, Эзэрхэх хүсэл эрмэлзлэл, 2011, х.1031). Барретт үүнийг тайлбарлахдаа “Ницше эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бүх сэтгэл зүйн сэдлийн үндэс болгож тодорхойлсон” (Барретт, Иррационал хүн, 2012, х.264) гэжээ. Ницше ёс суртахуун, нигилизм, үнэлгээ өгөх, рационал чанар нь бүгд эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн нэг хэлбэр байж болно гэж тодорхойлсон бол эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бүхэлд нь хүний сэтгэл хөдлөлтэй холбож сэтгэл зүйн үүднээс тайлбарласан үе бий. Иймээс түүнийхээр эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бататгах нь баяр баясал, таашаал авах мэт сэтгэл хөдлөлүүдээр илэрч болдог. Ницше энэ тухай өгүүлэхдээ баяр баясал нь бага зэргийн саад тотгорыг даван туулахаас үүдэлтэй эрх мэдэл, энэ нь нэг зүйлийн “эрх чөлөө” болж мэдрэгддэг гэж бичсэн нь эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг батлах нь эрх чөлөө гэх тодорхойлттой уялдаж байна.

Ф.Ницшегийн хоёр төрлийн ёс суртахууныг дахин авч үзье. Нэг нь хүнийг “сайн” болгох сул доройчуулын ёс суртахуун байсан бол нөгөө нь улам өргөжихийг хүсдэг хүчирхэг хүмүүсийн ёс суртахуун юм. Гэхдээ сул доройчуул сайн муу зэрэг үнэлэмж нь хүчирхэг хүмүүсийн эзэрхэх хүсэл эрмэлзлэлээс анх үүсэлтэй гэдгийг мартан

буцаагаад хүчирхэг хүний эсрэг байсан нь боолын ёс суртахуун эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг үгүйсгэхэд хүргэсэн юм. Эзэрхэх хүсэл эрмэлзлэл байнга сөргөлдөх хүчийг хайж байдаг бөгөөд ялалт байгуулсан ч сөрөг хүч устахгүй тул аль нэг ёс суртахуун бүрмөсөн устана гэж байхгүй, хэрэв нэг нь устаж нөгөө нь бие даан оршвол Ницшегийн хамгийн цэрвэж байдаг “өөрөөрөө байгаа ёс суртахуун” байх болно. Өөрөөр хэлбэл Ницшегийн хувьд “өөрөөрөө байгаа сайн”, “өөрөөрөө байгаа муу” оршихгүй юм.

Ф.Ницше эрх чөлөө бол эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бататгах явдал гэж тодорхойлсон. Мөн эзэрхэх хүсэл эрмэлзлэл нь боолын ёс суртахууны эсрэг байр суурьтай учир эрх чөлөө ч нэг зүйлийн ёс суртахуунлаг бус хүсэл эрмэлзлэлээр илрэх болно гэдэг санаагаа “Эзэрхэх хүсэл эрмэлзлэл” зохиолдоо илэрхийлсэн. Уламжлалт ёс суртахуун нь амьдралыг үгүйсгэдэг, хүчирхэг хүнийг үгүйсгэдэг, өөрийгөө ч үгүйсгэдэг нэг зүйлийн доройтлын логик тул түүнээс салж, хүн сэтгэл хөдлөлдөө шударга байж, шинэ үнэлэмжийг бүтээх урам зоригтой байдгаараа эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг баталдаг юм. Иймээс Ницшегийн хувьд эрх чөлөө бол хүнд байдаг уур сэтгэл хөдлөлөө мэдрэхээс үүдэлтэй баяр баясал байж болох юм.

Тэгвэл бидний бас нэг судлагдахуун болох Ж.П.Сартрын эрх чөлөөний үзэл нь өөрийн төлөөх ахуй буюу ухамсарт үндэслэдэг ч Ницшегийн адил сэтгэл зүйн тайлбар өгсөн байдаг. Хүн өөрийн эрх чөлөөний ухамсарт хүрэх нь айдас түгшүүр дунд л байлгадаг. Хэрэв хүсвэл түгшүүр нь ахуй дахь эрх чөлөөний ухамсрын орших хэлбэр гэж хэлж болно. Яг л ахуй дундах эрх чөлөө өөрийн ахуйд өөртөө асуулт тавьдаг (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.58). Эрх чөлөө бол асуулт тавихын зайлшгүй нөхцөл болж бидэнд олгогддог. Бид зөвхөн эрх чөлөөний талаарх онцгой ухамсар оршдогийг онцлон хэлэхийг хүссэн бөгөөд энэ ухамсар нь түгшүүр гэдгийг өмнө нь дурдсан билээ. (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.63).

Сартрынхаар бол хүн эрх чөлөөтэй үед байнга түгшүүр дунд байдаг, түгшүүр л эрх чөлөөг илэрхийлдэг. Гэхдээ яагаад түгшүүрээр дамжин илэрдэг эрх чөлөө нь абсолют эрх чөлөө байж, бас ч абсолют үүрэг хариуцлага дагуулдаг вэ гэдэгт хариулахад түүний ахуйн тухай сургаалыг авч үзэх шаардлагатай болно. Сартр ахуйг өөрөөрөө байгаа ахуй болон өөрийн төлөөх ахуй гэж тодорхойлсон бөгөөд энэ хоёрын харилцаа хамаарлын дундаас бид түүний эрх чөлөөний талаарх үзлийг ойлгож болох юм.

Ахуй бол өөрөө байгаа зүйл юм (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.25), ахуй бол байгаа зүйл мөн (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.25), өөрийн төлөөх ахуй бол байгаа зүйл биш бөгөөд биш байгаа тэр зүйл мөн (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.25). Тодруулбал, өөрөөрөө байгаа ахуй зүгээр л орших бөгөөд тунгалаг биш, хуваагдашгүй, хязгааргүй нягт, нэвтэршгүй. Өөрөөрөө байгаа ахуй оршин байхад юу ч хэрэггүй бол өөрийн төлөөх ахуй нь субстанцлаг шинжгүй бөгөөд зөвхөн өөрөөрөө байгаа ахуйн тохиолдлын шинжээс үүсэж бий болдог. Өөрийн төлөөх ахуй ямар ч агуулгагүй буюу цэвэр юу ч биш, мөн байнга өөрөөрөө байгаа ахуйг үгүйсгэх, юу ч биш болгохоор тэмүүлдэг.

Өөрийн төлөөх ахуй өөртөө заяагдмал юу ч биш байх ёстой. Ухамсрын ахуй нь өөртэйгөө нүүр тулах үедээ өөрөөсөө зайтай оршдог бөгөөд өөрийн ахуйгаасаа алсалдаг бүдэг зай нь юу ч биш юм (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.113). Өөрийн төлөөх ахуй бол өөрийгөө тодорхойлж байдаг ахуй, учир нь тэр өөртэйгөө давхцаж чадахгүй юм (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.113). Өөрөөр хэлбэл, Сартрын үзлээр өөрийн төлөөх ахуй болон ухамсар нь үнэн хэрэгтээ нэг юм, ухамсар

нь хэзээд өөртэйгөө давхцаж чаддаггүйгээс шалтгаалан, өөрийн төлөөх ахуй нь өөрийгөө тодорхойлох боломжтой болж байгаа юм.

Ухамсар эд юмс, ухамсрын өгөгдөхүүнүүдээс байнга дайжих үүрэгтэй. Энэ чөлөөт байдал бол ямар нэгэн юмнаас чөлөөтэй байх явдал гэж Сартр онцлон тэмдэглэжээ (Ж.П.Сартр, Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн, 2007, х.58). Ухамсар нь ямар нэгэн юмны төлөөх ухамсар байдаг тул эрх чөлөө ч мөн ямар нэгэн юмны төлөөх эрх чөлөө юм. Ухамсар туйлын чөлөөт байдалтай, Сартр ухамсрын биегүй шинжийг цэвэр бололцоо, хоосон байдал, ахуйгаар дүүрээгүй байдал гэж тайлбарлаад, ухамсар бол чөлөөт байдал мөн гэсэн тодорхойлолтод хүрчээ (Ж.П.Сартр, Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн, 2007, х.59). Өөрөөр хэлбэл, Сартр ухамсрын “дайжих”, “зугтах”, “үгүйсгэх”, “юу ч биш болгох” онцлог нь ухамсрын чөлөөт байдлын илэрхийлэл болдог. Тэгвэл ухамсрын абсолют эрх чөлөө хүнтэй хэрхэн холбогдож илрэхийг бид одоо авч үзэх болно.

“Эрх чөлөө ахуй биш: тэр нь хүний ахуй, өөрөөр хэлбэл, хүний ахуйн юу ч биш юм (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.536), эрх чөлөө болон өөрийн төлөөх ахуй нэг юм, хүн өөрт нь заяагдмал байдаг юу ч бишийнхээ хувьд эрх чөлөөтэй” (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.550). Тухайлбал, ухамсар нь юу ч биш болохоор түүнд ямар ч хязгаарлалт байхгүй, эрх чөлөөтэй байхаас өөр аргагүй. Хүн ухамсартай ахуй болсны хувьд хүний мөн чанарыг хүнээс өөр хэн ч тодорхойлохгүй, хүн өөрөө өөрийнхөө төсөл учир тасралтгүй өөрийгөө бүтээх, өөрийгөө тодорхойлох өөрийн төлөөх ахуй юм.

Өөрийн төлөөх ахуй болох хүн туйлын эрх чөлөөгөө хэрхэн хэрэгжүүлж байдгийг Сартр сонголтын тухай үзлээр дамжуулан харуулахыг оролджээ. Хүний хувьд ахуй нь өөрийн төлөөх сонголт юм (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.536), сонголт болон ухамсар хоёр ижил юм (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.561), эрх чөлөө бол сонголтоо хийх эрх чөлөө, харин сонголт хийхгүй байх эрх чөлөө биш, сонгохгүй байх нь хэрэгтээ “сонгохгүй”-г сонгосон явдал мөн (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.584). Өөрөөр хэлбэл, Сартрын эрх чөлөө нь үнэндээ тасралтгүй сонголт хийх явдал юм. Хүн эрх чөлөөгөө сонголтоор дамжин хэрэгжүүлдэг бөгөөд сонгохгүй байх боломжгүй болохоор абсолют шинжтэй юм, үүний улмаас Сартр хоригдол хүртэл өөрийн сонголт хийх эрх чөлөөтэй гэж үзэхэд хүрчээ.

Ж.П.Сартрын үзлээр хүн абсолют эрх чөлөөтэй. Гэхдээ абсолют эрх чөлөөтэй хүн абсолют үүрэг хариуцлага хүлээх ёстой гэж үзсэн нь Сартрын эрх чөлөөний тухай онтологийн хамгийн сонирхолтой хэсэг болно.

Түгшүүр, ганцаардал, хариуцлага нь далд буюу гэнэт л бидний ухамсрын чанарыг бүрдүүлдэг, учир нь бидний ухамсар бол цэвэр эрх чөлөө юм (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.563), хүн эрх чөлөөтэй ахуй болсны хувьд оршин байгаа ертөнц болон өөрийнхөө өмнөөс хариуцлага хүлээх ёстой (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.671). Өөрөөр хэлбэл, эрх чөлөө зайлшгүй зүйл тул хариуцлага ч зайлшгүй байдаг, эрх чөлөөнөөс зугтаж болдоггүйн адил хариуцлагаас ч зугтаж болдоггүй, тэгээд ч өөрийн төлөөх ахуй нь өөрийгөө бас энэ ертөнцийг тасралтгүй үгүйсгэж “оршин байлгаж” байгаа тул хүн заавал өөрийн сонголтдоо хариуцлага хүлээж байх хэрэгтэй.

Сартрын абсолют эрх чөлөөнөөс үүдэлтэй абсолют үүрэг хариуцлагын тухай тайлбарыг хураангуйлан дүгнэвэл :

1. Абсолют үүрэг хариуцлагыг хаа нэгтээс хүлээн аваагүй, бөгөөд бидний эрх чөлөөнөөс үүдэлтэй логик шаардлага юм (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.672).

Сартр хүн өөрийнхөө ахуйн үндэс суурь биш тул бүх зүйлд хариуцлага хүлээх ёстой, хариуцлагаас зутахдаа ч хариуцлага хүлээх ёстой гэж үзжээ.

2. Би туйлын эрх чөлөөтэй, миний сонгон авсан утга учир болон миний амьдарч байгаа цаг үе ялгаагүй юм (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.673). Хүн дайныг сонгосон бол дайны төлөө хариуцлага хүлээнэ, гэр бүлийг сонгосон бол гэр бүлдээ хариуцлага хүлээнэ, хүн заавал өөрийн сонголтдоо хариуцлага хүлээж байх ёстой.

3. Нөгөөтээгүүр, хүн зөвхөн өөрийн төлөөх ахуй төдийгүй бусдын төлөөх ахуй юм. Хүн субъектив чанарын хязгаарыг давж чадахгүй учир өөрийгөө сонгосноор бүх хүнийг ч сонгон авдаг. Сартр эрх чөлөө болон хариуцлагын тухай өгүүлэхдээ “өөрийн төлөөх ахуйн хариуцлага нь бүхий л хүн төрөлхтөн оршин суудаг дэлхий ертөнцөд тархан түгдэг” гэжээ (Ж.П.Сартр, Ахуй ба юу ч биш, 2014, х.675).

Ф.Ницше чөлөөт хүсэл эрмэлзлэлийн тухай өгүүлэхдээ хүн өөртөө тушааж чадна гэдэг хүсэл эрмэлзлэл чөлөөтэй гэсэн буй. Энэ нь түүний өөрийгөө захирч чаддаггүй нэгэн өөр нэгэнд захирагддаг гэх эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн тухай үзэлтэй уялдаж байна. М.Хайдеггер үүний тухай тайлбарлахдаа “тушаагч нь энэ ноёрхолд захирагддаг бөгөөд ингэснээр өөртөө захирагдаж байдаг” (М.Хайдеггер, Ницше, 2014, х.956), “тушаах нь өөрийгөө даван туулах хэрэг юм, энэ заримдаа захирагдахаас хэцүү байдаг” (М.Хайдеггер, Ницше, 2014, х.956) гэжээ.

Боол байх нь ч эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн нэг хэлбэр (М.Хайдеггер, 2014, х. 956), ертөнцийн эсрэг үгүйсгэл нь үнэн хэрэгтээ нэг зүйлийн нуугдмал эзэрхэх хүсэл эрмэлзлэл мөн (М.Хайдеггер, 2014, х.958). Өөрөөр хэлбэл, Ницшегийн үзэлд боолын ёс суртахуун буюу уламжлалт ёс суртахууны үнэлэмжүүд нь амьдралыг үгүйсгэх, хүнийг үгүйсгэх хэлбэрээр илэрч байдаг. Иймээс нигилизм ч эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн онцгой нэгэн хэлбэр юм.

Эзэрхэх хүсэл эрмэлзлэл бол үнэлэмжийг тогтоох цорын ганц зарчим мөн (М.Хайдеггер, Ницше, 2014, х.965). Өөрөөр хэлбэл, Ницшегийн хувьд эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг батлах бүхэн сайн, эрх чөлөөтэй байдаг бол эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг үгүйсгэх бүхэн муу, эрх чөлөөгүй юм.

Нигилизм нь зүгээр л хоосон байдал (Nichtigkeit)-ыг эрэлхийлдэггүй. Түүний жинхэнэ мөн чанар нь чөлөөлөлт (Befreiung)-ийг бататгах чанарт оршдог. Нигилизм бол хуучин үнэлэмжийн уналт бөгөөд энэ нь бүх үнэлэмжүүдэд туйлбартай эргүүлэг хийхэд чиглэдэг (М.Хайдеггер, Ницше, 2014, х.968). Тухайлбал, нигилизм нь хуучин үнэлэмжүүдийн уналтыг бэлгэдэж байснаас бүх үнэлэмжид туйлбартай эргүүлэг хийх үйл явц болон хувирдаг. Энэхүү төрлийн эргүүлэгт шинэ үнэлэмжийг бүтээх зайлшгүй шинж дагалддаг. М.Хайдеггерийн хэлсэнчлэн, бүх үнэлэмжийг хянан шинэчлэх нь ямар ч нөхцөл шаардахгүй хянан шинэчлэлт байх хэрэгтэй. Учир нь эзэрхэх хүсэл эрмэлзлэл бол ахуйн мөн чанар бөгөөд үнэлэмжийг шинэчлэх цорын ганц зарчим юм. Яг үүнтэй холбоотой Ницшегийн “Эзэрхэх хүсэл эрмэлзлэл” гэх зохиолд “чөлөөт хүсэл, нигилист хөдөлгөөн болсон философийн эсрэг шүүмжлэл” гэдэг гарчиг байдаг. Нигилизм хэрхэн үгүйсгэлээс баталгаа болж хувирах вэ гэдэг бол Ницшегийн ёс суртахууныг даван туулах, тэрчлэн эрх чөлөөг мэдрэхийн зангилаа мөн.

Нигилизм нь түүхэн үйл явцын “логик” болсны хувьд яагаад дээд үнэлэмжүүдийн уналт, мөн шинэ үнэлэмж үүсэхийн үндэс суурь болдгийг судалж үзэх хэрэгтэй. Нигилизм дээд үнэлэмжийг тогтоох, дээд үнэлэмжийг гажуудуулах, доош хийх, цаг үеийн шинж бүхий үнэгүйдэл, шинэ үнэлэмж хуучин үнэлэмжийг зайлшгүй орлох,

дахин үнэлэх шинэ тогтолцоо жич дахин үнэлэхийн бэлтгэл үе шатыг багтаадаг (М.Хайдеггер, Ницше, 2014, х.969).

Ф.Ницше нигилистуудын тухай өгүүлэхдээ, тэд бодит ертөнцийг байх ёсгүй гэж үзсэн, тэд байх ёстой ертөнцийг бодиттой оршиж байхгүй гэж үзсэн гэжээ. Эхлээд бодит ертөнцийг үгүйсгэж, ахиад бодит ертөнцөөс үүсэлтэй хүсэл мөрөөдлийг ч үгүйсгэсэн билээ. Гэхдээ энэхүү хоёрдмол үгүйсгэлийн ард оршин байгаа энэ ертөнцийг хүлээн зөвшөөрсөн, баталсан санаа явж байдаг. Идэвхтэй нигилизм нь өнгөрсний үнэлэмжийг нурааж, шинэ орон зайг бий болгосноор шинэ үнэлэмжийг бүтээх боломжийг олгосон. М.Хайдеггерийн дүгнэснээр, иймэрхүү идэвхтэй нигилизм нь хоосон орой болон эрх чөлөөг бүтээх онцлогтой юм. Энэ нь бэлэн байгаа зүйлсийг ч, тодорхой хүсэл мөрөөдлийг ч баталдаггүй, харин үнэлэмжийг үнэлэх зарчмыг буюу эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг баталдаг аж (М.Хайдеггер, Ницше, 2014, х.972).

Өөрөөр хэлбэл, уламжлалт ёс суртахууны дээд үнэлэмжүүдийг үгүйсгэх нь эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бататгах явдал мөн. Эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бататгах нь эрх чөлөө юм.

Ж.П.Сартрын туйлын эрх чөлөө нь өөртэйгөө давхцаж чадахгүй ухамсраас үүдэлтэй. Ухамсрын чөлөөт байдал хүн дээр хэрхэн биеллээ олохыг өгүүлэхдээ Сартр хүн өөрийнхөө ахуйг “зайлшгүй” сонгон авдаг гэжээ. Ингэснээр ухамсар буюу өөрийн төлөөх ахуйд онолоос практик руу шилжих боломж бий болсон юм. Бид ахуйг өөрсдөдөө оноохоос өөр аргагүй, энэ нь бидний танин мэдэхүйн давуу байдлыг тогтоож, мөн бидний үйлдлийг тодорхойлдог. Энэ зайлшгүй шинж чанар биднийг хамгийн үндсэн түвшинд бүрдүүлдэг учраас бид сонголтоо дагаж мөрдөх замаар өөрсдийгөө түүнээс салгах боломжгүй (Gardner, Сартрын хөтөч, 2022, х.189).

Сартрын хувьд энэ ертөнцийн өмнө хүлээх хариуцлага нь миний ертөнцийн өмнө хүлээх хариуцлагаас үүсдэг, харин миний ертөнцийн өмнө хүлээх хариуцлага миний эрх чөлөөт сонголтыг тусгадагтай холбоотой (Gardner, Сартрын хөтөч, 2022, х.204). Сартр хүнийг ертөнцийн бүтээгчийн хувиар ертөнцийн өмнө хариуцлага хүлээдэг гэж баталсан бөгөөд тэрхүү баталгаа нь “энэ дайн бол миний дайн” гэхдээ мэдээж би энэ дайныг зарлаагүй гэсэн дүгнэлтэд хүрэхийг зорьсон (Gardner, Сартрын хөтөч, 2022, х.204). Өөрөөр хэлбэл, Сартрынхаар хүн өөрийн ахуйн үндэс суурь биш гэсэн ч хүнээс хамааралтай ертөнцийн өмнө хариуцлага хүлээх ёстой, тэгээд ч түүнийхээр бол хүн эрх чөлөөгөө ухамсарлах нь өөрийн ахуйгаа ухамсарлахтай адил юм гэгдэгтэй судлаач Гарднер санал нэг байна.

Сартрын эрх чөлөөний тухай онтологид хүн эрх чөлөөгөө ухамсарлах нь үүрэг хариуцлагаа ухамсарлахын суурь болдог. Онтологийн эрх чөлөө нь сайн сайхны төлөөх эрх чөлөөтэй огт холбоогүй. Тиймээс хэрэв Сартр боол хүртэл бүрэн эрх чөлөөтэй, чөлөөлөгдөх шаардлагагүй гэж баталсан бол энэ нь үнэхээр утгагүй, дорд үзсэн хэрэг боловч онтологийн эрх чөлөө нь ийм утгагүй байдал, доромжлолыг агуулаагүй (Gardner, Сартрын хөтөч, 2022, х.209). Тодруулбал, уг судлаачийн үзэж буйгаар Сартр өөрийнхөө онтологи эрх чөлөөг бидний ердийн ойлголт дахь эрх чөлөөнөөс ялгаж салгахыг хичээсэн. Жишээлбэл, өдөр тутмын амьдралд эрх чөлөөний зааг хязгаар, хүрээ, нэмэгдэл багасалтын тухай ярьдаг бол Сартрын онтологи эрх чөлөө нь иймэрхүү “хязгаарлал”-аас ангид байх онцлогтой билээ.

Фридрих Ницшегийн хувьд хүсэл эрмэлзлэл бол чөлөөлөгч, баяр баяслыг мэдээлэгч юм. Хүсэл эрмэлзлэл хүнийг эрх чөлөөтэй болгодог, энэ л хүсэл эрмэлзлэл болон эрх чөлөөний жинхэнэ утга учир мөн (Ж.Делёз, Ницше ба философи, 2023,

х.157). Хүсэл эрмэлзлэлээс үүдэлтэй хязгаарлалтад Ницше хүсэл эрмэлзлэл нь чөлөөлөлт гэж тунхаглажээ; хүсэл эрмэлзлэлээс үүдэлтэй зовлонд тэрбээр хүсэл эрмэлзлэл нь баяр баясал гэж хэлсэн; урьдаас тогтоосон үнэлэмжийг хүсэх хүсэлд тэрбээр хүсэл эрмэлзлэл нь шинэ үнэлэмж гэж нотолсон (Ж.Делёз, Ницше ба философи, 2023, х.158). Тухайлбал, “Заратустра ингэж хэлсэн” гэх зохиол дахь эрх чөлөөний тухай өгүүлсэн мөртийг Ж.Делёз задлан шинжилсэн бөгөөд түүнийхээр Ницше эзэрхэх хүсэл өөрийгөө хүлж (ёс суртахуун) болдог учир мөн өөрийгөө чөлөөлж болдог, эзэрхэх хүсэл эрмэлзлэл хуучин үнэлэмжийг үгүйсгэж (ёс суртахууны үнэлэмжүүд) болдог учир ялгаагүй мөн шинэ үнэлэмжийг бүтээж болдог. Энэ нь эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг баталсан гэдэг утгаараа эрх чөлөөг илэрхийлж байгаа юм.

Фридрих Ницше болон Ж.П.Сартрын эрх чөлөөний талаарх үзэл яалт ч үгүй ёс зүйтэй холбогдож илэрдэг нь тодорхой байна. Ницшегийн хувьд ёс суртахууныг даван туулах нь эрх чөлөө бол Сартрын хувьд эрх чөлөө нь үүрэг хариуцлагын суурь болж байдаг.

Ницшегийн философийн амьдралын тухай онол нь эзэрхэх хүсэл эрмэлзлэлээс үүдэлтэй: амьдрал өөрөө эзэрхэх хүсэл эрмэлзлэлийн сайн тал нь юм. Дотоод сайн зүйл болохын хувьд амьдрал нь ёс зүйн шалгуур болж чадна. Тэгвэл, эзэрхэх хүсэл эрмэлзлэл болох амьдрал нь бүх үнэлэмжийг тодорхойлох шалгуур юм (Daigle, 2004). Тухайлбал, судлаач Дайглын тодорхойлсноор Ницшегийн философид эзэрхэх хүсэл эрмэлзлэл бол бүх үнэлэмжийг бүтээх зарчим учир эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг батлах, дэмжсэн бүхэн сайн, эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг үгүйсгэсэн бүхэн муу юм (жишээлбэл ёс суртахуун). Үүн дээр дөрөөлөөд хэлэхэд эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг үгүйсгэж байгаа үед хүн эрх чөлөөтэй биш, харин түүнийг бататгаж байдгаараа эрх чөлөөтэй юм.

Хэрэв бид Сартрын ёс суртахууны үндсэн зарчмыг томъёолох юм бол энэ нь дараах байдалтай байх юм: эрх чөлөөг батлах, хүндлэх, дэмжих бүх зүйл сайн; эрх чөлөөг үгүйсгэх, устгах бүх зүйл муу (Daigle, 2004). Өөрөөр хэлбэл, Сартрын ёс суртахууны зарчим эрх чөлөөгөө ухамсарлах, үүрэг хариуцлагаа ухамсарлахаас үүсэлтэй бол Ницшегийн хувьд ёс суртахууныг даван туулах, эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бататгах нь эрх чөлөө юм.

Бурхан тэнгэр” үхсэн нь Ницшегийнхээр дээд үнэлэмжүүдийн уналт, шинэ үнэлэмжийг бүтээх бэлтгэл үеийг бэлгэдэж байдаг бол судлаач Дайглын үзлээр Сартрын хувьд “Бурхан тэнгэр” үхсэн нь хүн төрөлхтний чөлөөлөлт бөгөөд энэхүү чөлөөлөлт нь нэг зүйлийн зэмлэл байсан тул тэрбээр хүнийг хаягдсан, эрх чөлөөтэй байхаар яллагдсан гэж үзээд бүхий л үйлдэлдээ хариуцлага хүлээх ёстой юм.

Эзэрхэх хүсэл эрмэлзлэл нь даван гарах буюу давж туулах зарчим бөгөөд амьдралыг өсөлт хөгжил рүү түлхэх хөдөлгөгч хүч гэж тайлбарлаж болно. Өөрийн төлөө ахуй нь нуугдмал ахуй бөгөөд тэр нь хэзээ ч бүрэн биелж чадахгүй боломжийг зорих ёстой. Сартрын өөрийн төлөөх ахуй нь Ницшегийн эзэрхэх хүсэл эрмэлзлийн тухай тодорхойлолттой маш ойр байдаг (Daigle, 2004).

Өөрөөр хэлбэл, уг судлаачийн үзлээр эзэрхэх хүсэл эрмэлзлэл нь хэвшмэл биш бөгөөд байнга бүрэлдэж байдаг тул Ницшегийн хувьд эрх чөлөө ч хэвшмэл ойлголт биш юм. Өөрийн төлөөх ахуй буюу ухамсар нь байнга ирээдүйд өөрийгөө төлөвлөж байдаг бөгөөд сонголтоор хэрэгжсэний дараа алга болдог, иймээс Сартрын эрх чөлөө ч тогтмол биш юм.

Дүгнэлт

Сэтгэл зүйн талаас Ницшегийн эзэрхэх хүсэл эрмэлзлэл нь сөргөлдөж буй хүчээ даван туулж, баяр баясал, эрх чөлөөг мэдэрдэг. Саад тогторыг даван туулсны үр дүнд хэр их хүч үлдэж байгаагаас шалтгаалан эрх чөлөөний тухай мэдрэмж өөр өөр байдаг. Үнэндээ эзэрхэх хүсэл эрмэлзлэл сөрөг хүчээ ялж, хэр илүүдэл үүснэ хүн төдий чинээ эрх чөлөөтэй байдаг. Харин Сартрын чөлөөт байдал болсон ухамсар нь өөрийгөө байнга ирээдүйд төлөвлөж, хязгааргүй олон боломжуудаар хүрээлүүлж байдаг бөгөөд сонголт бүхэндээ заавал хариуцлага хүлээх ёстой тул эрх чөлөө нь хүнд өгөгдөх түгшүүрээр илэрч байдаг. Өөрөөр хэлбэл, эрх чөлөө нь Ницшегийн хувьд нэг зүйлийн баяр баясал бол Сартрын хувьд нэг зүйлийн айдас түгшүүр байдаг нь сонирхолтой. Сартр эрх чөлөө нь хүнд зайлшгүй сэтгэлзүйн түгшүүр авчирдаг гэж үздэг. Ницше харин энэ түгшүүрийг даван туулж, өөрийгөө “үлэмж хүн” буюу “Übermensch” болгон хөгжүүлэхийг уриалдаг.

Гэвч эзэрхэх хүсэл эрмэлзлэл хаа сайгүй оршдог, амьгүй зүйлийн хүрээнд ч идэвхтэй байдаг. Сартр өөрийн төлөөх ахуй буюу ухамсар нь ганцхан хүнд байдаг гэж үзсэн тул эрх чөлөө нь зөвхөн хүний эрх чөлөө юм. Фридрих Ницше эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бататгаж, шинэ үнэлэмжийг бүтээх замаар нигилизмийг даван туулахыг хичээсэн бол Сартр эрх чөлөөтэйгөөр тасралтгүй төлөвлөж, төслөө хэрэгжүүлэхээр дамжуулан утга учрыг тодорхойлж утгагүй хоосон байдлыг даван туулах гэж оролдсон билээ.

Ф.Ницше “өөрөөрөө байгаа ёс суртахуун” байхыг хүлээн зөвшөөрөөгүй бол, Ж.П.Сартр априор ёс суртахуун байхыг хүлээн зөвшөөрөөгүй. Ницшегийн эзэрхэх хүсэл эрмэлзлэл хэрэгтээ бүх “өөрөөрөө байгаа зүйл”-ийн үгүйсгэл мөн. Энэ нь Ницшегийн ёс зүйн сургаалын үндэс нь өрнөдийн сэтгэлгээний түүхэн дэх метафизик ойлголтыг үгүйсгэсэн явдал гэдгийг харуулж байгаа юм. Харин Сартр хүн эрх чөлөөнөөс зугтах боломжгүйн адил хариуцлагаас зугтах боломжгүй гэж үзсэнээр туйлын эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн юм. Хоёулаа жинхэнэ эрх чөлөө гэдэг нь тогтсон хэм хэмжээнээс ангижрах явдал гэж үздэг. Гэхдээ Ницшегийн хувьд эрх чөлөө нь хүчирхэг байх, харин Сартрын хувьд хариуцлагатай сонголт хийх явдал юм.

Хоёр сэтгэгчийн эрх чөлөөний талаарх үзэл нь үгүйсгэл болон бататгалтай холбогдож байдаг. Ницшегийн хувьд ёс суртахууныг үгүйсгэж, эзэрхэх хүсэл эрмэлзлэлийг бататгах нь эрх чөлөө нь үгүйсгэлээс бататгал руу чиглэх явц байсан бол Сартрын хувьд эсрэг тэсрэг байдаг. Өөрөөрөө байгаа ахуй нь байгаа зүйл мөн гэдэг утгаар нэг зүйлийн эерэг шинж буюу бататгалыг агуулж байгаа бол өөрийн төлөөх ахуй нь байнга түүнийг үгүйсгэж байдаг. Өөрөөр хэлбэл Сартрын хувьд бататгал нь үгүйсгэл болон илэрдэг. Ницше юмсыг танин мэдэхээс захирах хүслийг илүүд үзсэн тул эзэрхэх хүсэл эрмэлзлэл бүх юмны үндэс суурь болдог бөгөөд амьдралыг тодорхойлох идэвхтэй хүч. Харин Сартрын хувьд эрх чөлөө бол үйлдэл хийхийн урьтал нөхцөл гэж үздэг тул үйлдэл хийх хүсэл эрмэлзлэл илүү чухал юм.

Ном зүй

1. Barrett, W. (2012). *Feilixing de ren [Irrational man]*. Shanghai Translation Publishing House.
2. Daigle, C. (2004). Sartre and Nietzsche: Brothers in arms. *Journal of Nietzsche Studies*, 27, 42–59.
3. Daigle, C. (2014). Le théâtre de Sartre: Morale de la liberté, morale nietzschéenne. *Sartre Studies International*, 20(2), 43–57.
4. Deleuze, G. (2023). *Niqie yu zhexue [Nietzsche and philosophy]*. Shanghai Literature

- and Art Publishing House.
5. Gardner, S. (2017). *Sartre*. Cambridge University Press.
 6. Gardner, S. (2022). *Daodu Sate “Cunzai yu xuwu” [An introduction to Sartre's “Being and nothingness”]* (W. Gongwei & J. Ting, Trans.). Chongqing University Press.
 7. Heidegger, M. (2014). *Niqie (shang xia ce) [Nietzsche (Vols. 1–2)]*. Commercial Press.
 8. Nietzsche, F. W. (2011). *Quanli yizhi (shang xia ce) [The will to power (Vols. 1–2)]*. Commercial Press.
 9. Sartre, J.-P. (2014). *Cunzai yu xuwu [Being and nothingness]*. SDX Joint Publishing Company.
 10. Thompson, N. (2008). Existentialist ethics: From Nietzsche to Sartre and beyond. *Ethics and Social Welfare*, 2(1), 10–23.
 11. Гомбосүрэн, Ц., & Дагзмаа, Б. (2022). *Амьдралын туйай философи*. Улаанбаатар: Тотопресс ХХК.
 12. Ницше, Ф. (2014). *Заратустра ингэж хэлсэн*. Монголын психотроникийн хүрээлэн.
 13. Сартр, Ж.-П. (2007). *Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн*. Улаанбаатар.

Relationship between freedom and ethics in the philosophy of Friedrich Nietzsche and Jean Paul Sartre

In the philosophies of Friedrich Nietzsche and Jean-Paul Sartre, the concept of freedom is closely related to ethics. For Nietzsche, freedom is an expression of one’s inner strength and the will to power—the drive to create oneself—and is manifested through the overcoming of traditional moral boundaries. In his framework, freedom is not about adhering to morality but about transcending it and generating new values. In contrast, Sartre sees freedom as inseparable from human consciousness, asserting that once a person recognizes their absolute freedom, they must also fully assume moral responsibility. Thus, freedom is not only the ability to choose, but the very foundation of ethical existence. This article analyzes each thinker’s conception of freedom in relation to their ethical standpoint, clarifying both their theoretical differences and commonalities to examine the philosophical relationship between freedom and ethics. In doing so, it seeks to reconceptualize freedom not merely as a subjective experience, but as an ethical category. Moreover, this comparison provides a theoretical foundation for rethinking contemporary ethical issues from a new perspective.